БАТЛАВ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Т.ЖАРГАЛСАЙХАН

"ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨХК

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2026 оны 01-р сарын 12 өдөр

Ажлын нэр: Кабель худалдан авах

Байршил: Өмнөговь аймаг Даланзадгад сум

Ажлын зорилго: Цахилгаан шугам сүлжээ, дэд станц, хуваарилах байгууламж, реле хамгаалалт, хоёрдогч хэлхээний тоноглол, хэрэглэгчийн шит хайрцгийн хэвийн найдвартай ажиллагааг хангах.

Ажлын технологийн үндсэн шаардлага: Цахилгаан байгууламжийн норм ба дүрэм /ЦБД/, холбогдох стандартыг баримтлах.

Дараах нөхцөлүүдийг нийлүүлэгч анхаарч ажиллана:

Нийлүүлэгдэх кабель, дагалдах хэрэгсэлийн тээвэрлэлт, хадгалалт, сав баглаа боодол нь ГОСТ 18690-82 "Кабель, дамжуулагч, утас ба кабелийн дагалдах хэрэгсэл. Барааны тэмдэглэгээ, сав баглаа, боодол нь тээвэрлэлт ба хадгалалт" стандартын шаардлагуудыг хангасан байх. Дээрх тоноглол нь "ТШТ: ЕШН Техникийн ерөнхий шаардлага ба нөхцөл"-ийн суурь норматив баримт бичгүүд дээр заасан бүх заалтыг мөрдсөн байх.

КАБЕЛЬ ДЭЭРХ ТЭМДЭГЛЭГЭЭ гадна бүрхүүлийн гадаргуу дээр дараах зүйлс тэмдэглэгдсэн байна:

- Хүчдэл
- Марк
- Хэмжээ
- Он

Үсэгнүүд нь цэх босоо том үсгээр бичигдсэн байх шаардлагатай. Нэг хэсэг товойлгосон үсэгнүүдийн төгсгөлөөс дараагийн хэсэг товойлгосон үсэгийн эхлэл хоорондын зай нь нэг метрээс хэтрэхгүй байна. Кабель бүр нь тэгээс эхлээд дамарны уртын хэмжээгээр нэг /1/ метрийн давтамжтайгаар тэмдэглэгдсэн байна. Хэрэв өнгөөр бичсэн бол энэ нь эрс ялгарахаар ба хэвийн орчны нөхцөлд арилахааргүй байх шаардлагатай.

Ажлын даалгавар:

СИП (өөрийгөө даах, тусгаарлах бүрээстэй утас) маягийн болон түүнтэй дүйцэхүйц цахилгаан дамжуулах шугамын утас байх ба техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагыг хангахын зэрэгцээ доор тусгасан тусгайлсан шаардлагыг

болон Монгол улсад мөрдөгдөж байгаа стандарт, шаардлагуудыг хангасан байна. ОХУ-ын СИП-2А болон БНХАУ-ын тусгаарлах бүрээстэй дамжуулагч утасны стандарт, шаардлагыг хангасан байна.

Нийлүүлэгч нь доорх үзүүлэлтүүдтэй ижил болон түүнээс дээш шаардлагыг хангасан бүтээгдэхүүн санал болгох ба зарим үзүүлэлтүүд доор заасан үзүүлэлтээс доош байхыг хүлээн зөвшөөрөхгүй.

СИП дамжуулагчын техникийн үзүүлэлтийн үндсэн шаардлага:

СИП дамжуулагчын 0 утас нь XLPE тусгаарлагатай, фазын 3 утас нь UV/XLPE тусгаарлагатай утасны багцын жинг 0-ийн утсаар дамжуулан авдаг байна.

Дамжуулагч утасны тусгаарлагч материал нь PVC, PE бол зөвшөөрөхгүй.

Дамжуулагч утасны тусгаарлагч материал нь XLPE PVC, PE болохыг нүдээр харж нотлоход дутагдалтай тул туршилтын бичгийг шаардана. Дамжуулагч утасны хэт ягаан туяаны хамгаалалтыг нотлох үйлдвэрлэгчийн туршилтын бичгийг мөн шаардана. Дээрх туршилтын бичиг нь баталгаажсан байх шаардлагатай.

Дамжуулагч утасны тусгаарлагч материалыг XLPE материал болохыг нотлох үйлдвэрлэгчийн болон үйлдвэрлэгчээс үл хамаарах туршилтын бичгийг хавсаргаж ирүүлнэ. Туршилтын бичгийг ирүүлээгүй, дутуу ирүүлэх нь техникийн шаардлагад нийцээгүйд тооцох үндэслэл болохыг анхааруулж байна.

Хийцийн үндсэн шаардлага:

Стандартын шаардлагад нийцсэн СИП дамжуулагч утасны 0-ийн утас нь XLPE тусгаарлагатай, фазын 3 утас нь UV/XLPE тусгаарлагатай утасны багцын жинг 0-ийн утсаар дамжуулан авдаг байх.

№	Үзүүлэлт	СИП2А 3х50+1х54.6	СИП2А 3х70+1х70
1	Дамжуулагч	Хөнгөн цагаан	Хөнгөн цагаан
2	Нойлын судлын дамжуулагч	Ган	Ган
3	Хөндлөн огтлол	50мм2	70мм2
4	Нойлын судлын хөндлөн огтлол	54.6мм2	70мм2
5	Гадна бүрээс	XLPE - зүймэл хэрээст полиэтилен тусгаарлага **(PVC, PE, HDPE материал байхыг зөвшөөрөхгүй)** **Туршилтын бичиг, гэрчилгээ, сертификатаар баталгаажуулсан байна.**	
6	Тусгаарлагчийн зузаан	1.5 мм	1.7 мм
7	Гадна бүрээс өнгө	Хар өнгөтэй гадны цаг агаарын үйлчлэлд тэсвэртэй	
8	Ажиллах хамгийн их температур	90 °C	

9	Суурилуулалтын үеийн температур	-20 °С хүртэл,	
10	Богино залгааны үеийн хамгийн их температур (5 хүртэл секундын хугацаанд)	250 °С	
11	Хэвийн давтамж, Гц	50 Гц	
12	Хэт ягаан туяаны хамгаалалт	Тусгай хэт ягаан туяаны хамгаалалтын бүрээстэй байна. Сертификатаар баталгаажуулсан байна.	
13	Нийт дамжуулагчийн диаметр	35 мм	38мм
14	Жин, кабель	779 кг/км	1012 кг/км
15	Хүчдэлийн түвшин	Uo /U = 0,6/1 кВ	
16	Агаарт байрлуулахад хамгийн их ачааллын гүйдэл	195 А	240 А
17	Ашиглалтын орчны температур	-40 °С-аас +60 °С хүртэл	

10кВ СИП-50, АС-70 дамжуулагч техникийн үзүүлэлтийн үндсэн шаардлагууд:

Цахилгаан дамжуулах агаарын шугамын угсралтад тусгаарлагатай, тусгаарлагагүй гант хөнгөн цагаан утсыг хэрэглэх ба дараах шаардлагыг хангасан байна Үүнд:

Утасны бүтэц: Ган зүрхэвч болон хөнгөн цагаан судлаас бүрдсэн утас

- Төрөл: Ган зүрхэвчтэй СИП 50/8, АС 70/11

- Материал: Гант-хөнгөн цагаан

- Утасны гол: Зэвэрдэггүй ган

- Судал: Хөнгөн цагаан утас

- 10, 35 кВ ЦДАШ-д ашиглагдана.

Ашиглалтын хугацаа: 45 жил-ээс багагүй

10кВ СИП-50/8 маркийн гант-хөнгөн цагаан дамжуулагч:

Үзүүлэлтүүд	Шаардлага
Дамжуулагчийн марк	СИП-50/8
Дамжуулагчийн материал	Хөнгөн цагаан
Гүйдэл дамжуулах судлын стандарт хөндлөн огтлол	50 мм2

Ган утасны хөндлөн огтлол	8.4 мм2
Гадна диаметр, мм	9,6 мм
Удаан хугацааны зөвшөөрөгдөх температур, °С,	+90°С ихгүй байх
Ашиглалтын температур °С	-70°С аас +90°С хооронд
Зөвшөөрөгдөх гүйдлийн хэмжээ, А (агаарт)	210 А
Утасны таталтын хүч кН	17,112
Жин, кг/м	0,195 кг/м-аас багагүй
Цаг агаарын нөхцөл, орчны ангилал	УХЛ1; ГОСТ 15150-69-ийн дагуу
Цахилгаан дамжуулагчийн идэвхтэй эсэргүүцэл (20°С/ 1 Ом/км)	0,720 Ом/км
Ашиглалтын хугацаа	45 жилээс багагүй

АС-70/11 маркийн гант-хөнгөн цагаан дамжуулагч:

Үзүүлэлтүүд	Шаардлага
Дамжуулагчийн марк	АС-70/11
Дамжуулагчийн материал	Хөнгөн цагаан
Гүйдэл дамжуулах судлын стандарт хөндлөн огтлол	70 мм2
Ган утасны хөндлөн огтлол	11 мм2
Гадна диаметр, мм	11,4 мм
Удаан хугацааны зөвшөөрөгдөх температур, °С,	+90°С ихгүй байх
Ашиглалтын температур °С	-70°С аас +90°С хооронд
Зөвшөөрөгдөх гүйдлийн хэмжээ, А (агаарт)	265 А
Утасны таталтын хүч кН	24,130
Жин, кг/м	0,276 кг/м-аас багагүй
Цаг агаарын нөхцөл, орчны ангилал	УХЛ1; ГОСТ 15150-69-ийн дагуу

Цахилгаан дамжуулагчийн идэвхтэй эсэргүүцэл (20°С/ 1 Ом/км)	0,4218 Ом/км

Хоёрдогч хэлхээний кабель шугамуудын техникийн үзүүлэлтийн үндсэн шаардлагууд.

КВВГ 6*2.5мм кабелийн техникийн шаардлага:

К- Контролны
В- Үндсэн тусгаарлагч ПВХ (поливинилхлорид)
В- Кабелийн бүрээс ПВХ (поливинилхлорид), давхар тусгаарлагчтай
Г- Гадна хамгаалалтын бүрхүүл
6- Жилийн тоо
2.5- Дамжуулагчийн хөндлөн огтлол

КВВГ 4*2.5мм кабелийн техникийн шаардлага:

К- Контролны
В- Үндсэн тусгаарлагч ПВХ (поливинилхлорид)
В- Кабелийн бүрээс ПВХ (поливинилхлорид), давхар тусгаарлагчтай
4- Жилийн тоо
2.5- Дамжуулагчийн хөндлөн огтлол

Кабелиуд нь дараах олон усын цахилгаан техникийн стандартуудад заасан шаардлагад нийцэж байх ёстой.

- IEC 60121 Халалтад тэсвэртэй хөнгөн цагаан дамжуулагчтай цахилгааны утас
- IEC 60228 Кабелийн тусгаарлага
- IEC 60230 Кабель болон тоноглолын импульсийн туршилт
- IEC 60287 Кабелийн гүйдлийн тооцоо
- IEC 60391 Тусгаарлагчийн тэмдэглэгээ
- IEC 60446 Хүн ба тоноглолын аюулгүй ажиллах дүрэм, таних тэмдэг тэмдэглэгээ.
- Дамжуулагчийг өнгө ба дугаараар таних
- IEC 60540 Кабелийн тусгаарлага болон щитний туршилт

Кабель дээрх тэмдэглэгээ:

Гадна бүрхүүлийн гадаргуу дээр дараах тэмдэглэгээтай байна:

- Хүчдэл
- Марк
- Хэмжээ

Хоёр, гурав, дөрвөн дамжуулагчтай хүчний кабель нь бугд IEC 60466-д заагдсаны дагуу дугаар ба өнгөөр танигдаж байх шаардлагатай. Кабелийг дамарт ороомог хэлбэрээр ороож үзүүрүүдийг ус чийг нэвтрэхгүйгээр битүүмжилсэн байна.

АВВГ 4х25 мм кабелийн техникийн шаардлага:

- Буултын кабель АВВГ /4*25/ кабель
- А — Гүйдэл дамжуулагч материал нь хөнгөн цагаан,
- В — Үндсэн тусгаарлагч ПВХ (поливинилхлорид),
- В — Кабелийн бүрээс ПВХ (поливинилхлорид),

- Г — Хуяггүй

Щит хайрцаг доторх монтажыг / **ПВ1 - 1*4 мм /** кабель:

- П - Гадна бүрээс
- В - Зэс
- 1 – Хатуу

Щит хайрцаг доторх монтажыг / **ПВ1 - 1*6 мм /** кабель:

- П - Гадна бүрээс
- В - Зэс
- 1 – Хатуу

Щит хайрцаг доторх монтажыг / **ПУГВ – 2*4 мм /** кабель:

- П - Гүйдэл дамжуулагч материал нь зэс
- У — Кабелийн бүрээс ПВХ (поливинилхлорид),
- Г - Хуяггүй
- В — уян кабель

ПВ3 1*4мм2 кабель:

- П - Гадна бүрээс
- В - Зэс
- З - Уян

ПВ1 1*2.5 мм2 кабель:

- П - Гадна бүрээс
- В - Зэс
- 1 - Хатуу

ПВ3 1*2.5 мм2 кабель:

- П - Гадна бүрээс
- В - Зэс
- З - Уян

№	Үзүүлэлтүүд	Техникийн үзүүлэлт						
1	Дамжуулагчийн марк	ПВ-1*4мм	ПВ-1*6мм	ПУГВ-2*4 мм	АВВГ-4*25 мм	ПВ3 1*4мм2	ПВ1 1*2.5 мм2	ПВ3 1*2.5 мм2
2	Дамжуулагийн материал	Зэс	Зэс	Зэс	Хөнгөн цагаан	Зэс	Зэс	Зэс
3	Гүйдэл дамжуулах судлын стандарт хөндлөн огтлол	4мм	6мм	4мм	25мм	4мм	2.5мм	2.5мм
4	Нойлын судлын гүйдэл дамжуулах	-	-	-	25мм			

	стандарт хөндлөн огтлол							
5	Гүйдэл дамжуулах судлын тоо	1	1	2	4	1	1	1
6	Дамжуулагчийн тусгаарлага	Поливинилхлорид						
7	Тусгаарлагийн зузаан, мм	0.6 мм						
8	Удаан хугацаанд зөвшөөрөгдөх температур	+70 С						
9	Ашиглалтын температур	-50 С, +50 С хооронд						
10	Зөвшөөрөгдөх гүйдлийн хэмжээ /агаарт/	39А		22А	67А	-	-	-
11	Зөвшөөрөгдөх гүйдлийн хэмжээ/Газар доор/	47А		30А	77А	-	-	-
12	1 сек-ийн богино залгааны зөвшөөрөгдөх гүйдлийн хэмжээ кА	0.29кА		180 А	1,13кА	0.29кА	0.12кА	0.15кА
13	Дамжуулагч дээр богино залгааны үеийн зөвшөөрөгдөх дээд температур С	+160 С						
14	Цахилгаан дамжуулагчийн идэвхтэй эсэргүүцэл	12,6 Ом/км		1,98 Ом/км		12,6 Ом/км		

0.4 кВ Хүчний кабель шугамын техникийн үзүүлэлтийн үндсэн шаардлага:

д/д	Техникийн үзүүлэлт	Утга					
		XLEP-3*240+1*120	**XLEP-3*150+1*95**	**XLEP-3*120+1*70**	**XLEP-3*95+1*70**	**XLEP-3*70+1*54**	**XLEP-3*50+1*35**
1	Ажлын хүчдэл (В)	1200					
2	Хэвийн хүчдэл (В)	660					

3	Дамжуулагчийн хөндлөн огтлолын талбай (мм²)	3*240+1*120	3*150+1*95	3*120+1*70	3*95+1*70	3*70+1*54	3*50+1*35
4	Давтамж (Гц)	50					
5	Гадна орчны температур (°C)	-50....+250					
6	1 км кабелийн жин (кг)	3420	2430	1883	1550	1190	884
7	Далайн түвшин	1000 метрээс дээш өндөрт ажиллах боломжтой байх					
8	Харьцангуй чийгшил (%)	98					
9	Зөвшөөрөгдөх ачаалал (А)	410	369	341	261	180	140
10	Хийц	Хөнгөн цагаан					
11	Кабелийн судалын тусгаарлагчийн зузаан (мм)	1.9 мм-ээс багагүй					
12	Кабелийн тусгаарлагчийн төрөл	Полиэтилен					
13	Богино залгааны гүйдлийн хязгаар (кА)	9.5	8.66	7.54	6.86	4.95	4.95
14	Туршилтын прокотол	Монгол улсын эрх бүхий мэргэжлийн лабораторид туршсан протоколтой байна					

10 кВ- ын хүчний кабель:

д/д	Үзүүлэлтүүд	Шаардлага 3х95мм2 кабель	Шаардлага 3х120мм2 кабель	Шаардлага 3х185мм2 кабель
1	Дамжуулагчийн материал	Хөнгөнцагаан		
2	Хэлбэр дүрс	Нягтруулсан		
3	Судал дахь тоо, хөндлөн огтлол	36мм		
4	Дамжуулах судлын нийлбэр	95мм2	120 мм2	185мм2
5	Дамжуулах хөндлөн огтлол	11.1мм	12.8мм	14.5мм
6	Хүчдэл	8.7/15кВ		
7	Тусгаарлага материал	XLPE		
8	Хэвийн зузаан	4.5мм		
9	Хамгийн бага	4.4мм		
10	Тусгаарлагын хагас дамжуулагч	0.7мм		

11	Зэс туузны	25x0.1мм	25x0.2мм	25x0.4мм
12	Туузан экраны	100%		
13	Кабелийн ороолтын чиглэл	Баруун		
14	Дүүргэгч	Гигроскоп биш дүүргэгч		
15	Дотор бүрээсний материал	HDPE		
16	Дотор бүрээсний зузаан	1.6мм	1.7мм	1.9мм
17	Ган туузан хуягны зузаан	0.5мм		
18	Ган туузан хуягны бүрээс	100%		
19	Гадар бүрээсний материал	HDPE		
20	Гадар бүрээсний өнгө	хар		
21	Гадар бүрээсний зузаан	3мм	3.1мм	3.4мм
22	Гадар бүрээсний хамгийн бага зай	3мм		
23	Гадар бүрээсний гадаад	66мм	85мм	120мм
24	Угсралтын	14D		
25	Угсралтын температур	50°C, -50°C		

10 кВ-ын төгсгөлийн муфьт /ЗКНТП-10-(70-120), ЗПСТ-10-(150-240) ТӨРЛИЙН/

Худалдан авалтаар нийлүүлэгдэх муфтнууд нь ГОСТ-13781.0-86 "10-35кВ хүртэлх хүчдлийн түвшинтэй хүчний кабелийн муфт" стандарт шаардлагыг хангахын зэрэгцээ дараах шаардлагуудыг давхар хангасан байна. Үүнд:

№	Үзүүлэлт	Техникийн шаардлага
1	Онцгой анхаарах зүйлс:	• 10кВ-ын төгсгөлийн муфтнууд нь цаас тосон тусгаарлагатай болон хөндлөн хэрээст полиэтилэн тусгаарлага бүхий кабельд зориулагдсан байх. • Төрлөөс хамааран ОХУ-д төгсгөлийн ЗКнТП, ЗКвТП маркийн муфттэй дүйцэхүйц болон түүнээс илүү үзүүлэлттэй байх.

2	Иж бүрдэл	• Иж бүрдлийн жагсаалт нь үйлдвэрлэгчээс баталгаажуулсан тамга, тэмдэгтэй байх . • Холболтын муфт нь хавсралт-1-т заасан иж бүрдэлтэй байх • Доорх иж бүрдэл үйлдвэрлэгчээс шалтгаалан өөрчлөгдөж болно. Зайлшгүй шаардлагатай иж бүрдэл дутуу тохиолдолд захиалагчтай зөвшилцөн шаардлагатай
3	Агшилтын коэффициент	Муфтны халуун суулттай эд ангиудын агшилтын коэффициент нь 3-аас багагүй байх.
4	Эд ангиудад анхаарах зүйлс:	• Халуун суулттай эд ангиуд /хоолой, багалзуур, манжет/ нь гэмтээгүй, ан цав, цууралт, цоорхойгүй байх ба гадаргуу болон ирмэг хэсгүүд нь тортог, бохирдол, цэврүү гэх мэт гадаргуугийн ямар нэгэн согоггүй байх. • Угсралтын явцад халуун суулттай эд ангиуд нь нийт урт болон тойргийн дагуу жигд суудаг, мөн хийн горелкийн дөлөнд гадаргуугийн өөрчлөлт маш бага буюу анхны уртын 5%-аас хэтрэхгүй агшилт үүсдэг байх. • Халуун суулттай эд ангиуд дээр тэмдэглэгээ байх бөгөөд ГОСТ-18690 стандартын дагуу үйлдвэрлэгч, агшилтын диапазон, дугаарыг кирилл үсгээр тодорхой тэмдэглэсэн байх. Энэхүү шаардлага нь бүх иж бүрдлийн материал, түүний дотор мастик холбогч төгсгөвчид мөн хамаарна. • 10кВ-ын холболтын муфтны хамгаалалтын бүрээс /кожух/-д уртын дагуу дотор гадаргуу нь жигд цавуу түрхэгдсэн халууны суулттай хоолойг хэрэглэнэ. • 10кВ-ын холболтын муфтны хамгаалалтын бүрээс нь агаарын үйлчлэл, элэгдэлд тэсвэртэй хийгдсэн байх. • 10кВ-ын холболтын муфтны иж бүрдэлд чангалахад тасардаг толгой бүхий боолтон холбогчтой /гильз/ байх • Эдгээр нь зэс эсвэл хөнгөн цагаан кабелийн цул, задгай, мөн дугуй,

		сектор хэлбэртэй судлын алинд ч хэрэглэж болох зориулалттай байх. • Тусгаарлагч лентний ерөнхий зориулалт нь цаг агаарын хүнд нөхцөлд тэсвэртэй цахилгаан болон механик шинж чанар сайн байх ёстой. Лентийг IEC60454 стандартын дагуу 25 мм өргөнтэй 1 ширхэг нь 20 м урттай ороосон байна. Энэ лентийг 900 С хүртэлх температурт хэрэглэхэд тохиромжтой байх ёстой. • 10кВ-ын кабелийн муфтны тусгаарлагыг дахин шинэчлэхэд энэхүү лентийг хэрэглэнэ.
5	Сертификат , гэрчилгээ	Нийлүүлэх бараа материалын үйлдвэрлэгчийн сертификат, ГОСТ 13781.0-86 стандартад нийцсэн тохирлын гэрчилгээ, угсралтын заавар, зураг, каталоги зэргийг заавал ирүүлнэ.
6	Ашиглалты н хугацаа	Бүх муфтны ашиглалтын хугацаа нь кабелийн ашиглалтын хугацаатай ижил буюу 30 жил байх.
7	Тэмдэглэгээ	Бүх тэмдэглэгээ нь хялбар ялгагдахаар бичигдсэн байх.
8	Баглаа боодол	• Бүх дагалдах хэрэгслүүд болон зааврууд нь муфтны баглаа боодол дотор хийгдсэн байх. • Муфтны дагалдах хэрэгслүүдийг нямбай баглаж боосон, нягт битүүмжилсэн байх.
9	Шалгалт, туршилт	• Импульсийн хүчдлийн туршилт • Чийгтэй болон давстай орчны туршилт • Богино залгааны үеийн дулааны гүйдлийн туршилт • Мөчлөгийн /циклические/ туршилт Богино залгааны үеийн динамик гүйдлийн туршилт • ГОСТ-13781.0-86 стандартын дагуу халалтын туршилт • Цахилгаан соронзон орны шуугиан /помех/ тэсвэрлэх туршилт
10	Хадгалалт	Бүх хэрэгсэл, материалууд +400С-өөс -400С градуст ямарваа гэмтэл болон элэгдэл үүсгэхгүй байх бүрэн нөхцөлийг хангасан байранд хадгалагдана. Баглаа боодол дээр нь тухайн материалын хадгалагдах хугацааг тэмдэглэж бичсэн байна.

11	Тээвэрлэлт ба зөөвөрлөлт	Муфт бүрийг хүлээлгэн өгөхдөө бүх нэрийн хэрэгсэл, материал, багаж болон муфт, муфтны хамгаалалтын боодол ороолт зэргийг нэг бүрчлэн бичиж бэлдсэн байна.
12	Үйлдвэрлэсэн он	2025 оноос хойш



Тээвэрлэлт ба хадгалалт сав баглаа боодол:

Нийлүүлэгдэх бараа материалын тээвэрлэлт, хадгалалт, сав баглаа боодол нь ГОСТ 18690- 82 "Кабель, дамжуулагч, утас ба кабелийн дагалдах хэрэгсэл. Барааны тэмдэглэгээ, сав баглаа, боодол тээвэрлэлт ба хадгалалт" стандартын шаардлагуудыг хангасан байх ёстой. Дээрх тоноглол нь " ТШТ: ЕШН Техникийн ерөнхий шаардлага ба нөхцөл" - ийн суурь норматив баримт бичгүүд дээр заасан бүх заалтыг мөрдсөн байх ёстой ба кабелиудыг зориулалтын дамарт заавал ороосон байна.

Жич:

- Санал болгож буй барааны захиалагчийн техникийн шаардлага болон нийлүүлэгчийн техникийн үзүүлэлтийг харьцуулсан хүснэгтээр бэлтгэж дээжийн хамт ирүүлнэ.
- Гэрээ байгуулсаны дараа нийлүүлэх барааг техникийн шаардлагын тодорхойлолтын дагуу шалгаж, тулгасны дараа хүлээн авах ба шаардлагад нийцээгүй тохиолдолд захиалагч нь барааг хүлээн авахгүй бөгөөд гэрээг цуцлахыг анхаарах. Үүнээс үүдэн гарах зардлыг захиалагч хариуцахгүй.
- Нийлүүлэх барааны техникийн өгөгдөл, туршилтын бичиг, чанарын баталгааг хавсаргаж хүлээлгэн өгнө.

Ажлыг хүлээн авах:

- Захиалагч байгууллагаас ажлын даалгаврын дагуу хяналтыг үе шат бүрт хийнэ.
- Компанийн Гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдсон комисс шаардлагууд болон даалгаварын дагуу хянаж шалган акт үйлдэж хүлээн авна.

ХЯНАСАН:

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР Т.ГАНТӨМӨР

БОЛОВСРУУЛСАН:

ЦШС-ИЙН АЛБАНЫ ДАРГА: М.БАНЗРАГЧ